БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шинэжинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2021/17/СТА-ТТЗ**


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn


Баянхонгор
2020 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын гэрчилгээ ..... 2

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 3

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ..... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ..... 4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 11
3. Аудитын тайлан ..... 12

3.1. Ерөнхий зүйл ..... 12

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 12

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ..... 12

3.4 Материаллаг байдал ..... 13

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт ..... 13
3.5.1 Мөнгөн хөрөнгө ..... 13
3.5.2 Авлага ..... 13
3.5.3 Бараа материал ..... 14

3.5.7 Үндсэн хөрөнгө ..... 15
3.5.8 Өр төлбөр ..... 16
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо ..... 16
3.5.10 Орлогын данс ..... 17
3.5.11 Зардлын данс ..... 18
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 18
3.7 Шилэн дансны мэдээлэл ..... 20

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 21

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 21

**3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал** .. 22
4. Менежментийн захидал ..... 22

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 24

6. Хавсралт 2.: Харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт /мянган төгрөгөөр/ ..... 25


## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СХС | Сум хөгжүүлэх сан |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.САЙХАНБАЯР ТАНАА

2021.03.25 № 2/189

танай ______________ -ны № ______________ -т

# АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шинэжинст сумын Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэжинст сумын Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шинэжинст сумын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийт 9 зорилтын хүрээнд 59 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 89.5 хувийн биелэлтэй тайлагнасан байна.

Сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор “Хангалттай” гэж үнэлсэн байна.

2021 А4 ТООТ

005020270

Сумын Засаг даргын 2020 оны А/А/14 дугаар захирамжаар байгуулагдсан сумын онцгой комисс, мэргэжлийн анги нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хор уршгийг арилгах талаар төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын удирдлагад санал, холбогдох бусад байгууллагад үүрэг өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих чиг үүрэг хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **865,493,405.86** | **712,859,261.50** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 251,299,614.37 | 164,001,789.52 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 251,299,614.37 | 164,001,789.52 |
| **3121** | **Төгрөг** | 251,299,614.37 | 164,001,789.52 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 251,299,614.37 | 164,001,789.52 |
| **33** | **АВЛАГА** | 55,118,184.56 | 202,316,053.66 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 280,018.34 | 969,724.24 |
| **335** | **Бусад авлага** | 22,863,246.22 | 23,269,419.42 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 22,863,246.22 | 23,269,419.42 |
| **336** | **Зээлийн авлага** | 31,974,920.00 | 178,076,910.00 |
| **3361** | **Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага** | 31,974,920.00 | 178,076,910.00 |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 31,974,920.00 | 178,076,910.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 549,075,606.93 | 336,541,418.32 |
| **351** | **Түүхий эд материал** | 119,850,519.00 | 136,433,681.23 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 118,575,949.00 | 121,782,017.66 |
| 35130 | Эм боох материал | 1,274,570.00 | 14,651,663.57 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 250,000,000.00 | 25,000,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 21,985,829.64 | 7,408,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 106,803,258.29 | 117,263,737.09 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,600,740.00 | 4,869,740.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 33,439,699.00 | 36,434,827.80 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 800,000.00 | 800,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.40 | 1,000,000.40 |
| 35460 | Хүнсний материал | 67,700.00 | 1,059,950.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 68,895,118.89 | 73,099,218.89 |
| 35600 | Мал амьтад | 50,436,000.00 | 50,436,000.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 36600 | Бусад нөөц | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,987,759,151.85** | **6,324,074,321.39** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 5,987,759,151.85 | 6,324,074,321.39 |
| **392** | **Биет хөрөнгө** | 5,809,811,485.39 | 6,145,636,654.97 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 6,030,962,891.49 | 6,676,870,546.86 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (882,216,765.48) | (1,151,277,893.66) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 277,612,006.00 | 277,702,006.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (135,191,654.58) | (161,022,795.54) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 494,039,280.44 | 539,979,309.44 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (349,803,724.76) | (385,537,182.17) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 279,929,840.94 | 321,217,334.94 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (138,829,858.91) | (174,582,011.17) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 1,638,838.00 | 1,638,838.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 253,390,376.13 | 253,390,376.13 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (47,013,354.01) | (81,016,883.99) |
| 39217 | Ном | 25,293,610.13 | 28,275,010.13 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 177,947,666.46 | 178,437,666.42 |
| 39301 | Програм хангамж | 2,100,000.00 | 2,050,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,100,000.00) | (1,450,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 178,516,000.00 | 178,516,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (568,333.54) | (678,333.58) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6,853,252,557.71** | **7,036,933,582.89** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,856,234.50** | **14,427,248.86** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3,856,234.50 | 14,427,248.86 |
| **413** | **Өглөг** | 3,856,234.50 | 14,427,248.86 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 568,082.00 | 8,451,055.16 |
| **4136** | **Бусад өглөг** | 3,288,152.50 | 5,976,193.70 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 3,288,152.50 | 5,976,193.70 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,849,396,323.21** | **7,022,506,334.03** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 6,849,396,323.21 | 7,022,506,334.03 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,422,292,372.93 | 2,422,292,372.93 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,422,292,372.93 | 2,422,292,372.93 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,333,523,011.35 | 2,807,112,908.90 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,123,131,680.77 | 2,634,002,898.08 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 210,391,330.58 | 173,110,010.82 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,093,580,938.93 | 1,793,101,052.20 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** VI=IV+V | **6,853,252,557.71** | **7,036,933,582.89** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,795,148,155.86** | **3,124,029,910.97** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **71,717,002.92** | **105,705,058.04** |
| **110** | **Орлогын албан татвар** | 54,555,902.92 | 82,463,294.04 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 54,555,902.92 | 82,463,294.04 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 15,900,210.56 | 31,820,150.00 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 38,655,692.36 | 49,069,144.04 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | | 1,574,000.00 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 7,057,000.00 | 1,102,000.00 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 5,935,000.00 | - |
| 113002 | Бууны албан татвар | 1,122,000.00 | 1,102,000.00 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 10,104,100.00 | 22,139,764.00 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | 5,181,300.00 | 7,382,600.00 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 811,300.00 | 1,152,600.00 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 700,000.00 | - |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 3,670,000.00 | 6,230,000.00 |
| **1181** | **Газрын төлбөр** | - | 13,797,999.00 |
| 118101 | Газрын төлбөр | | 13,797,999.00 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | 4,467,000.00 | 959,165.00 |
| 118203 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 4,467,000.00 | 959,165.00 |
| **1183** | **Бусад татвар** | 455,800.00 | - |
| 118304 | Нохойны албан татвар | 455,800.00 | - |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **505,804,368.44** | **799,597,813.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 505,804,368.44 | 799,597,813.93 |
| 120003 | Торгуулийн орлого | 10,340,000.00 | 3,297,566.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 495,464,368.44 | 796,300,247.93 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 9,412,024.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 76,347,020.00 | 33,731,901.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 419,117,348.44 | 753,156,322.93 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,217,626,784.50** | **2,218,727,039.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,151,187,500.00 | 1,240,806,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,151,187,500.00 | 1,240,806,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 21,093,174.50 | 142,247,009.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,158,216.80 | 62,885,904.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 934,957.70 | 79,361,105.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,035,106,800.00 | 813,888,770.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 548,473,100.00 | 525,933,800.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 486,633,700.00 | 287,954,970.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 10,239,310.00 | 21,784,560.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 10,239,310.00 | 21,784,560.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,356,698,090.06** | **2,913,672,570.53** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,356,698,090.06** | **2,913,672,570.53** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,297,784,517.24 | 2,787,919,187.71 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,061,207,925.00 | 1,225,018,947.73 |
| 210101 | Үндсэн цалин | 944,004,574.00 | 1,041,551,605.78 |
| 210102 | Нэмэгдэл | 60,152,006.00 | 82,018,382.72 |
| 210104 | Урамшуулал | 57,051,345.00 | 101,448,959.23 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 133,446,690.28 | 153,455,305.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,254,965.45 | 104,239,073.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,936,771.63 | 11,896,676.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,833,804.52 | 9,929,418.26 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,010,338.35 | 2,464,389.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,410,810.33 | 24,925,746.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 161,985,920.00 | 163,264,150.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,907,989.00 | 9,421,527.00 |
| 210302 | Түлш, халаалт | 152,058,131.00 | 153,067,623.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,019,800.00 | 775,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 68,533,458.00 | 95,792,001.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,555,220.00 | 8,470,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,155,333.00 | 60,133,462.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,613,500.00 | 10,480,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,368,000.00 | 1,816,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,221,600.00 | 3,078,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,284,000.00 | 4,110,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,335,805.00 | 7,701,939.20 |
| **2105** | **Нормативт зардал** | 111,299,878.28 | 91,911,950.70 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,365,263.28 | 39,570,830.70 |
| 210502 | Хоол, хүнс | 82,071,515.00 | 49,762,320.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,863,100.00 | 2,578,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,279,166.00 | 7,280,350.00 |
| 210602 | Тавилга | 354,800.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 15,924,366.00 | 7,280,350.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,279,000.00 | 9,536,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 1,000,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,279,000.00 | 9,536,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 30,180,995.84 | 71,991,198.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 27,142,833.84 | 68,653,502.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,400,000.00 | 1,751,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | 357,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 460,580.00 | 313,668.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 135,300.00 | 30,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 542,282.00 | 885,728.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 704,571,483.84 | 969,669,284.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 322,423,673.96 | 538,719,122.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,436,350.00 | 7,385,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 373,711,459.88 | 423,565,062.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 58,913,572.82 | 125,753,382.82 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 51,154,064.00 | 68,822,126.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 12,045,894.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,898,215.00 | 12,007,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,376,255.00 | 25,220,864.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 29,495,340.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,833,700.00 | 2,098,722.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,834,074.50 | 6,300,000.00 |
| 213405 | нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2,834,074.50 | 6,300,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,925,434.32 | 50,631,256.82 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,925,434.32 | 50,631,256.82 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **438,450,065.80** | **210,357,340.44** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 228,058,735.22 | 37,247,329.62 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 143,398,237.42 | 1,577,499.98 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 84,660,497.80 | 35,669,829.64 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (228,058,735.22) | (37,247,329.62) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **210,391,330.58** | **173,110,010.82** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,397,357,777.42** | **2,390,775,098.04** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **71,717,002.92** | **105,705,058.04** |
| **110** | **Орлогын албан татвар** | 54,555,902.92 | 82,463,294.04 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 54,555,902.92 | 82,463,294.04 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 15,900,210.56 | 31,820,150.00 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 38,655,692.36 | 49,069,144.04 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | | 1,574,000.00 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 7,057,000.00 | 1,102,000.00 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 5,935,000.00 | - |
| 113002 | Бууны албан татвар | 1,122,000.00 | 1,102,000.00 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 10,104,100.00 | 22,139,764.00 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | 5,181,300.00 | 7,382,600.00 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 811,300.00 | 1,152,600.00 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 700,000.00 | - |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 3,670,000.00 | 6,230,000.00 |
| **1181** | **Газрын төлбөр** | - | 13,797,999.00 |
| 118101 | Газрын төлбөр | | 13,797,999.00 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | 4,467,000.00 | 959,165.00 |
| 118203 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 4,467,000.00 | 959,165.00 |
| **1183** | **Бусад татвар** | 455,800.00 | - |
| 118304 | Нохойны албан татвар | 455,800.00 | - |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **105,577,300.00** | **66,343,001.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 105,577,300.00 | 66,343,001.00 |
| 120003 | Торгуулийн орлого | 10,340,000.00 | 3,297,566.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 95,237,300.00 | 63,045,435.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,890,280.00 | 31,113,534.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 76,347,020.00 | 31,931,901.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,220,063,474.50** | **2,218,727,039.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,151,187,500.00 | 1,240,806,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,151,187,500.00 | 1,240,806,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 21,093,174.50 | 142,247,009.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,158,216.80 | 62,885,904.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 934,957.70 | 79,361,105.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,035,106,800.00 | 813,888,770.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 548,473,100.00 | 525,933,800.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 486,633,700.00 | 287,954,970.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 12,676,000.00 | 21,784,560.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 2,436,690.00 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 10,239,310.00 | 21,784,560.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,697,754,056.37** | **2,155,655,055.89** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,697,754,056.37** | **2,155,655,055.89** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,636,098,808.55** | **2,029,901,773.07** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,060,062,028.95 | 1,214,001,077.94 |
| 210101 | Үндсэн цалин | 899,428,745.60 | 973,023,688.51 |
| 210102 | Нэмэгдэл | 97,508,179.35 | 127,683,890.49 |
| 210104 | Урамшуулал | 63,125,104.00 | 113,293,498.94 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 133,786,951.60 | 157,279,908.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 92,203,827.12 | 110,018,649.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,469,970.63 | 11,583,319.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,192,133.52 | 9,208,017.61 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,081,458.00 | 2,413,631.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,839,562.33 | 24,056,291.01 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 162,089,520.00 | 166,324,582.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,571,958.00 | 9,529,693.00 |
| 210302 | Түлш, халаалт | 152,046,642.00 | 155,873,055.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,470,920.00 | 921,834.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 66,802,703.00 | 90,045,177.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,116,370.00 | 8,916,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,930,883.00 | 59,772,077.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,426,200.00 | 10,725,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,784,000.00 | 1,820,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,327,600.00 | 3,245,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,217,650.00 | 5,566,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 116,726,308.00 | 75,341,050.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,753,527.00 | 17,076,980.00 |
| 210502 | Хоол, хүнс | 81,974,615.00 | 50,672,470.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,998,166.00 | 7,591,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,854,400.00 | 10,290,850.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,846,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 18,854,400.00 | 8,444,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,279,000.00 | 9,536,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 1,000,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,279,000.00 | 9,536,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 31,824,097.00 | 255,759,873.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,785,935.00 | 253,032,005.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,400,000.00 | 1,751,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | 357,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 460,580.00 | 313,668.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 135,300.00 | 30,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 542,282.00 | 275,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 35,673,800.00 | 51,323,255.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,171,700.00 | 32,691,055.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,502,100.00 | 18,632,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,655,247.82** | **125,753,282.82** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 53,895,739.00 | 68,822,026.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 2,436,690.00 | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 12,225,700.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,898,215.00 | 12,007,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,501,434.00 | 25,220,864.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 29,495,340.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,833,700.00 | 2,098,622.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,834,074.50 | 6,300,000.00 |
| 213405 | нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | 2,834,074.50 | 6,300,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,925,434.32 | 50,631,256.82 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,925,434.32 | 50,631,256.82 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **699,603,721.05** | **235,120,042.15** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **658,012,024.00** | **322,417,867.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **658,012,024.00** | **322,417,867.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 658,012,024.00 | 322,417,867.00 |
| 220001 | Барилга байгууламж | 565,155,524.00 | 274,285,167.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 92,856,500.00 | 48,132,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(658,012,024.00)** | **(322,417,867.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 41,591,697.05 | (87,297,824.85) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 209,707,917.32 | 251,299,614.37 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 251299614.37 | 164001789.52 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,422,292,372.93 | 2,095,284,289.93 | 2,121,428,329.77 | 6,639,004,992.63 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 1,703,351.00 | 1,703,351.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,422,292,372.93** | **2,095,284,289.93** | **2,123,131,680.77** | 6,640,708,343.63 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | -1,703,351.00 | | -1,703,351.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | 210,391,330.58 | 210,391,330.58 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,422,292,372.93** | **2,093,580,938.93** | **2,333,523,011.35** | 6,849,396,323.21 |
| **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **2,422,292,372.93** | **2,093,580,938.93** | **2,333,523,011.35** | 6,849,396,323.21 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 300,479,886.73 | 300,479,886.73 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,422,292,372.93** | **2,093,580,938.93** | **2,634,002,898.08** | 7,149,876,209.94 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | -300,479,886.73 | | -300,479,886.73 |
| Тайлант үеийн үр дүн | | | 173,110,010.82 | 173,110,010.82 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,422,292,372.93** | **1,793,101,052.20** | **2,807,112,908.90** | 7,022,506,334.03 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,448,515,900.00 | 2,285,194,657.07 | 163321242.9 | 93.33 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,101,066,300.00 | 2,010,909,490.07 | 90156809.9 | 95.71 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,081,770,100.00 | 1,996,803,668.07 | 84966431.9 | 95.92 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,234,181,400.00 | 1,214,001,077.94 | 20180322.1 | 98.36 |
| 210101 | Үндсэн цалин | 980,478,700.00 | 973,023,688.51 | 7455011.5 | 99.24 |
| 210102 | Нэмэгдэл | 136,303,400.00 | 127,683,890.49 | 8619509.5 | 93.68 |
| 210104 | Урамшуулал | 115,399,300.00 | 113,293,498.94 | 2105801.1 | 98.18 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,000,000.00 | - | 2000000.0 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 164,756,200.00 | 157,279,908.13 | 7476291.9 | 95.46 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 115,812,800.00 | 110,018,649.10 | 5794150.9 | 95.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,269,600.00 | 11,583,319.01 | 686281.0 | 94.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,779,500.00 | 9,208,017.61 | 571482.4 | 94.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,444,900.00 | 2,413,631.40 | 31268.6 | 98.72 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,449,400.00 | 24,056,291.01 | 393109.0 | 98.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 171,821,000.00 | 166,324,582.00 | 5496418.0 | 96.80 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,072,900.00 | 9,529,693.00 | 543207.0 | 94.61 |
| 210302 | Түлш, халаалт | 160,188,100.00 | 155,873,055.00 | 4315045.0 | 97.31 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,560,000.00 | 921,834.00 | 638166.0 | 59.09 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 99,058,700.00 | 93,026,577.00 | 6032123.0 | 93.91 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,163,900.00 | 8,916,100.00 | 247800.0 | 97.30 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 63,319,100.00 | 59,772,077.00 | 3547023.0 | 94.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,549,600.00 | 10,725,000.00 | 1824600.0 | 85.46 |
| 210404 | Ном, хэвлэл | 5,214,100.00 | 4,801,800.00 | 412300.0 | 92.09 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,245,300.00 | 3,245,300.00 | 0.0 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,566,700.00 | 5,566,300.00 | 400.0 | 99.99 |
| **2105** | **Нормативт зардал** | 99,432,900.00 | 75,341,050.00 | 24091850.0 | 75.77 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,826,500.00 | 17,076,980.00 | 2749520.0 | 86.13 |
| 210502 | Хоол, хүнс | 71,580,500.00 | 50,672,470.00 | 20908030.0 | 70.79 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,025,900.00 | 7,591,600.00 | 434300.0 | 94.59 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 54,616,900.00 | 49,338,350.00 | 5278550.0 | 90.34 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 26,151,000.00 | 24,594,000.00 | 1557000.0 | 94.05 |
| 210602 | Тавилга | 14,500,000.00 | 14,149,500.00 | 350500.0 | 97.58 |
| 210604 | Урсгал засвар | 13,965,900.00 | 10,594,850.00 | 3371050.0 | 75.86 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 14,264,900.00 | 9,536,000.00 | 4728900.0 | 66.85 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,264,900.00 | 9,536,000.00 | 4728900.0 | 66.85 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 182,524,900.00 | 175,159,468.00 | 7365432.0 | 95.96 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 179,121,400.00 | 172,431,600.00 | 6689800.0 | 96.27 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,237,500.00 | 1,751,000.00 | 486500.0 | 78.26 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 423,500.00 | 357,300.00 | 66200.0 | 84.37 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 356,600.00 | 313,668.00 | 42932.0 | 87.96 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 70,000.00 | 30,000.00 | 40000.0 | 42.86 |
| 210807 | Газрын төлбөр | 315,900.00 | 275,900.00 | 40000.0 | 87.34 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 61,113,200.00 | 56,796,655.00 | 4316545.0 | 92.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,227,100.00 | 38,164,455.00 | 4062645.0 | 90.38 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,886,100.00 | 18,632,200.00 | 253900.0 | 98.66 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 19,296,200.00 | 14,105,822.00 | 5190378.0 | 73.10 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,296,200.00 | 14,105,822.00 | 5190378.0 | 73.10 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,691,100.00 | 12,007,200.00 | 4683900.0 | 71.94 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,605,100.00 | 2,098,622.00 | 506478.0 | 80.56 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **347,449,600.00** | **274,285,167.00** | 73164433.0 | 78.94 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 347,449,600.00 | 274,285,167.00 | 73164433.0 | 78.94 |
| 220001 | Барилга байгууламж | 347,449,600.00 | 274,285,167.00 | 73164433.0 | 78.94 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,448,515,900.00 | 2,194,666,675.07 | 253849224.9 | 89.63 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,240,806,700.00 | 1,190,175,443.18 | 50631256.8 | 95.92 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,240,806,700.00 | 1,190,175,443.18 | 50631256.8 | 95.92 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,007,330,600.00 | 919,661,236.89 | 87669363.1 | 91.30 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 659,881,000.00 | 631,706,266.89 | 28174733.1 | 95.73 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 347,449,600.00 | 287,954,970.00 | 59494630.0 | 82.88 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 24,773,800.00 | 21,784,560.00 | 2989240.0 | 87.93 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 24,773,800.00 | 21,784,560.00 | 2989240.0 | 87.93 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 175,604,800.00 | 63,045,435.00 | 112559365.0 | 35.90 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 32,975,000.00 | 31,113,534.00 | 1861466.0 | 94.35 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,200,000.00 | 31,931,901.00 | -30731901.0 | 2,660.99 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 141,429,800.00 | | 141429800.0 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 172,823,314.10 | -172823314.1 | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 82,295,332.10 | -82295332.1 | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 752 | 748 | 4 | 99.47 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 6 | 6 | 0 | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 6 | 6 | 0 | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 107 | 105 | 2 | 98.13 |
| 620001 | Удирдах ажилтан | 12 | 11 | 1 | 91.67 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 68 | 68 | 0 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 27 | 26 | 1 | 96.30 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 532 | 532 | 0 | 100.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 406 | 406 | 0 | 100.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 406 | 406 | 0 | 100.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 126 | 126 | 0 | 100.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 126 | 126 | 0 | 100.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **107** | **106** | 1 | 99.07 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 9 | 0 | 100.00 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 40 | 40 | 0 | 100.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 3 | 3 | 0 | 100.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 17 | 17 | 0 | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 31 | 30 | 1 | 96.77 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 7 | 7 | 0 | 100.00 |

## 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 20,158,216.80 | 135,947,009.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 20,158,216.80 | 135,947,009.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 20,158,216.80 | 135,947,009.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 18,259,100.00 | 80,600,405.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,259,100.00 | 80,600,405.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 630,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 630,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 54,716,204.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 54,716,204.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 25,220,864.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 29,495,340.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,899,116.80 | - |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | - |
| 213405 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 1,899,116.80 | - |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 20,158,216.80 | 135,947,009.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 20,158,216.80 | 135,947,009.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,158,216.80 | 62,885,904.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 73,061,105.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинэжинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Н.Сайханбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 10-аас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэв.

Шинэжинст сумын Засаг дарга нь 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 298 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Шинэжинст сумын Засаг даргаар 2010 он 1 сараас 10 сар хүртэл З.Мөнхтөр, 2020 оны 11 дүгээр сараас Н.Сайханбаяр, санхүүгийн албаны даргаар Х.Дагважав ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн захиргааны байгууллага болж иргэддээ шударга, шуурхай,ил тод , нээлттэй үйлчилнэ" гэж тодорхойлжээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд: Хүний хөгжлийн дээдлэн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй дэмжиж иргэдийг тогтвортой ажлын байраар хангах, ядуурлыг бууруулахад төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх нь байгууллагын эрхэм зорилт юм.

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Шинэжинст сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Шинэжинст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Шинэжинст сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

| Байгууллагын ангилал | Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|
| | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Итгэл үзүүлсэн | Аудитад хамрагдаагүй |
| **Төсвийн шууд захирагч** | 4 | 3 | 1 | - |
| **Дүн** | 4 | 3 | 1 | - |

## 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2584756.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 51695.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3637375.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 36373.7 мянган төгрөгөөр тооцов.

## 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 251299.6 мянга, эцсийн үлдэгдэл 164001.8 мянган төгрөг болж, 1763.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө | 251299.6 | 164001.8 | (87297.8) | 100.0 |
| **Дүн** | **251299.6** | **164001.8** | (87297.8) | 100.0 |

*Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 164001.8 мянган төгрөг нь төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн 27374.7 мянга, орон нутгийн төсвөөс сумын ЗДТГ, ИТХ-д дутуу олгосон 54331.8 мянган төгрөгийн санхүүжилт нийт 81706.5 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 58501.7 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 23793.6 мянган төгрөг байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 55118.1 мянга, эцсийн үлдэгдэл 202316.0 мянган төгрөг болж 147197.9 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл / мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагсадтай холбогдсон авлага | 280.0 | 969.7 | 689.7 |
| Байгууллагаас авах авлага | 22863.2 | 23269.4 | 406.2 |
| Зээлийн авлага | 31974.9 | 178076.9 | 146102.0 |
| **Дүн** | **55118.1** | **202316.0** | **147197.9** |

*Эх сурвалж: Шинэжинст сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тус сумын нийт авлагын 87.0 хувийг Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Тайлант хугацаанд ерөнхий боловсролын сургууль 9950.0 мянга, сум хөгжүүлэх сан 144098.5 мянган төгрөг үүссэн нь голлох нөлөө үзүүлж байна.

*Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 226.0 | 34.1 | (191.9) | |
| ЗДТГ | | 12103.5 | 12103.5 | |
| Сургууль | 20.4 | 9950.0 | 9929.6 | |
| Цэцэрлэг | 2783,5 | 3119.6 | 336.1 | |
| Эрүүл мэндийн төв | 4446.6 | 798.2 | (3648.4) | |
| Соёлын төв | | 237.3 | 237.3 | |
| Сум хөгжүүлэх сан | 31974.9 | 176073.4 | 144098.5 | |
| Орон нутгийн хөгжлийн сан | 15666.7 | | (15666.7) | |
| **НИЙТ ДҮН** | **55118.1** | **202316.1** | **147198.0** | |

*Эх сурвалж: Шинэжинст сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын насжилтаар нь авч үзвэл Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, соёлын төвийн авлагууд тайлант онд үүссэн авлагууд байна.

Харин сум хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 31974.9 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант хугацаанд 25292.2 мянган төгрөгийг шүүхэд шилжүүлж авлагыг барагдуулж 6682.7 мянган төгрөгийн авлага нь шүүхийн шийдвэр гарч шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжсэн бөгөөд тухайн онд шинээр 7 иргэн 1 аж ахуйн нэгжид зээл олгож 144098.5 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн байна.

Засаг даргын Тамгын газар тайлант онд 12103.5 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн байна. Үүнд малчдаас авах өвс тэжээлийн үнэ 2003.5 мянга, аймгийн “Ойн анги”-д шилжүүлсэн 7000.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн авлага, “Хонгор ойл” ХХК-аас авах шатахууны авлага 3100.0 мянган төгрөг тус тус шинээр үүссэн байна.

Хүүхдийн цэцэрлэг нь оны эхэнд 2783.5 мянган төгрөгийн авлагатай бөгөөд үүний 2750.0 мянган төгрөг 2012 онд үүссэн “Ган мөнхжин” ХХК-аас авах зураг төсвийн авлага байна. Үүний хариуцагч нь нас барсан тул эзэн холбогдогчгүй авлага байна.

Ерөнхий боловсролын сургууль цахим самбарын үнэнд 9950.0 мянган төгрөг шилжүүлж хөрөнгө орлого аваагүй авлага үүсгэсэн байна.

Соёлын төв, Эрүүл мэндийн төвүүдэд ХАОАТ, үйлдвэрчний эвлэлийн авлага шинээр үүссэн байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 559075.6 мянга, эцсийн үлдэгдэл 346541.4 төгрөг болж, 212534.2 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 118575.9 | 121782.0 | 3206.1 |
| Эм боох материал | 1274.6 | 14651.7 | 13377.1 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 250000.0 | 25000.0 | (225000.0) |
| Бэлэн бүтээгдэхүүн | 21985.8 | 7408.0 | (14,577.8) |
| Бичиг хэргийн материал | 3600.7 | 4869.7 | 1269.0 |
| Аж ахуйн материал | 33439.7 | 36434.8 | 2995.1 |

| | | | |
|---|---|---|---|
| Сэлбэг хэрэгсэл | 800.0 | 800.0 | |
| Түлш, шатах тослох материал | | 1000.0 | 1000.0 |
| Хүнсний материал | 67.7 | 1060.0 | 992.3 |
| Бусад хангамжийн материал | 68895.1 | 73099.2 | 4204.1 |
| Мал амьтад | 50436.0 | 50436.0 | |
| Нөөцийн бараа | 10000.0 | 10000.0 | |
| **Дүн** | **559075.6** | **346541.4** | **(212,534.2)** |

*Эх сурвалж: Шинэжинст сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

- Бараа материалын дансны үлдэгдэл 346541.4 мянган төгрөг болж өмнөх оноос 212534.2 мянган төгрөгөөр буурсан нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийсэн ажлаас дуусаагүй үйлдвэрлэл дансанд 250000.0 мянган төгрөгийг цэвэр усны байгууламжийг бүртгэсэн байсан бөгөөд тайлант хугацаанд ашиглалтад орсонтой холбоотой байна.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 1937.4 | 2056.9 | 119.5 | 0.61 |
| ЗДТГ | 130492.4 | 124805.9 | (5,686.5) | 34.11 |
| Сургууль | 75743.9 | 71571.9 | (4,172.0) | 21.27 |
| Цэцэрлэг | 57052.4 | 62895.7 | 5843.3 | 18.69 |
| Эрүүл мэндийн төв | 41568.4 | 57930.0 | 16361.6 | 17.21 |
| Соёлын төв | 2281.0 | 2281.0 | | 0.68 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 250000.0 | 25000.0 | (225,000.0) | 7.43 |
| **НИЙТ ДҮН** | **559075.5** | **346541.4** | **(212,534.1)** | **100.0** |

*Эх сурвалж: Шинэжинст сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 323867.4 мянган төгрөгийн бараа материалын 283636.1 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 39709.7 төгрөгийн материал шилжүүлэн авсан, бусад байдлаар 521.6 мянган төгрөг нэмэгдсэн байна.

Тайлант онд ИТХ 119.5 мянга, Засаг даргын Тамгын газар 20288.3 мянга,эрүүл мэндийн төв 19301.9 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн авсан байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | 323867.4 | Хасагдсан | 536401.6 |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 283636.1 | Худалдсан, зарцуулсан | 472385.3 |
| Шилжүүлэн авсан | 39709.7 | Шилжүүлсэн | 21985.8 |
| бусад | 521.6 | бусад | 42030.4 |

*Эх сурвалж: Шинэжинст сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7543482.8 мянга, эцсийн үлдэгдэл 8279639.4 мянган төгрөг болж, 736156.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **БИЕТ ХӨРӨНГӨ** | 7362866.8 | 8099073.4 | 736206.6 | **97.8** |
| Барилга байгууламж, орон сууц | 6030962.9 | 6676870.5 | 645907.7 | 80.6 |
| Тээврийн хэрэгсэл | 277612.0 | 277702.0 | 90.0 | 3.4 |
| Машин тоног төхөөрөмж | 494039.3 | 539979.3 | 45940.0 | 6.5 |
| Тавилга эд хогшил | 279929.8 | 321217.3 | 41287.5 | 3.9 |
| Түүх соёлын дурсгалт зүйл | 1638.8 | 1638.8 | - | 0.02 |
| Номын фонд | 25293.6 | 28275.0 | 2981.4 | 0.3 |
| Бусад үндсэн хөрөнгө | 253390.4 | 253390.4 | - | 3.1 |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | 180616.0 | 180566.0 | (50.0) | **2.2** |
| Программ хангамж | 2100.0 | 2050.0 | (50.0) | 0 |
| Бусад биет бус хөрөнгө | 178516.0 | 178516.0 | - | 2.2 |
| **НИЙТ ДҮН** | **7543482.8** | **8279639.4** | **736156.6** | **100.0** |

*Эх сурвалж: Шинэжинст сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

- Тайлант онд 761457.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 93.6 хувь буюу 713325.0 мянган төгрөгийг хөрөнгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна. Үүнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Засаг даргын Тамгын газарт 584601.5 мянга, Эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 36097.0 мянга, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургуульд 87378.0 мянга, цэцэрлэгт 5248.5 мянган төгрөгийг тус тус орлого авсан байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 9,355.0 | 9,635.0 | 280.0 | 0.1 |
| Засаг даргын Тамгын газар | 3,885,219.6 | 4,479,185.2 | 593,965.5 | 54.1 |
| Соёлын төв | 257,306.4 | 267,106.4 | 9,800.0 | 3.2 |
| Эрүүл мэндийн төв | 764,051.2 | 803,668.4 | 39,617.1 | 9.7 |
| Ерөнхий боловсролын сургууль | 1,784,669.8 | 1,864,265.9 | 79,596.1 | 22.5 |
| Цэцэрлэг | 842,880.8 | 855,778.6 | 12,897.8 | 10.3 |
| **НИЙТ ДҮН** | 7,543,482.8 | 8,279,639.4 | 736,156.6 | 100.0 |

*Эх сурвалж: Шинэжинст сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тухайн онд 48132.7 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 713325.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн авсан байна.

Мөн ашиглалтгүй болсон программ хангамжийг аймгийн ИТХ-ын тогтоолоор ИТХ 200.0 мянга, ЗДТГ 200.0 мянган төгрөгийн акталсан байна.

*Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| | | | |
|---|---|---|---|
| Нэмэгдсэн | **761,457.7** | Хасагдсан | **25,301.2** |
| Худалдан авсан | 48,132.7 | Худалдсан | 0.0 |
| Хандиваар | 0.0 | Акталсан | 25,301.2 |
| Шилжүүлэн авсан | 713,325.0 | Бусад | |

*Эх сурвалж: Шинэжинст сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3856.2 мянга, эцсийн үлдэгдэл 14427.2 мянган төгрөг болж 10571.0 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН | 3856.2 | 14427.2 | 10571.0 | 100.0 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 568.1 | 8,451.1 | 7,883.0 | 58.6 |
| Байгууллагад төлөх өглөг | 3,288.2 | 5,976.2 | 2,688.0 | 41.4 |
| **Дүн** | 3,856.2 | 14,427.2 | 10,571.0 | 100.0 |

*Эх сурвалж: Шинэжинст сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөр нь 14427.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд эрүүл мэндийн төвийн өглөг 12758.3 хувь буюу 88.4 хувийг эзэлж байгаа нь голлох нөлөө үзүүлж байна.Үүнд 5325.1 мянган төгрөгийн эмийн өглөг, 6543.8 мянган төгрөгийн ХАОАТ-ын өглөг, 889.5 мянган төгрөгийн үйлдвэрчний эвлэлийн өглөг шинээр үүссэн байна.

*Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 231.8 | 1017.8 | 786.0 | 7.1 |
| ЗДТГ | 0 | 609.8 | 609.8 | 4.2 |
| Эрүүл мэндийн төв | 423.1 | 12758.3 | 12,335.2 | 88.4 |
| ОНХС | 2850 | 0 | (2,850.0) | - |
| Сургууль | 61.1 | 39.9 | (21.2) | 0.3 |
| Цэцэрлэг | 290.2 | 1.4 | (288.8) | 0.0 |
| **НИЙТ ДҮН** | 3,856.2 | 14,427.2 | 10,571.0 | 100.0 |

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6849396.3 мянга, эцсийн үлдэгдэл 7022506.3 мянган төгрөг болж, 173110.0 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,422,292.4 | 2,422,292.4 | - | 34.5 |
| Өмч: - төрийн | 2,422,292.4 | 2,422,292.4 | - | 34.5 |
| **Хуримтлагдсан үр дүн** | 2,333,523.0 | 2,807,112.9 | 473,589.9 | 40.0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,093,580.9 | 1,793,101.1 | (300,479.9) | 25.5 |
| **Дүн** | 6,849,396.3 | 7,022,506.3 | 173,110.0 | 100.0 |

Эх сурвалж: Шинэжинст сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс 173110.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 173110.0 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Мөн ЗДТГ нь 2019 онд хөрөнгө акталсан ба акталсан хөрөнгийн дахин үнэлгээг бууруулаагүйтэй холбоотой 298800.6 мянган төгрөгийг тайлант үед нягтлан бодогч залруулсан, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль тайлант хөрөнгө актлаж 1679.2 мянган төгрөгийн дахин үнэлгээг тус тус бууруулсан байна.

### 3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2019.12.19-ний өдрийн хуралдаанаар 15 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 90740.0 мянга, хүү торгуулийн орлогыг 5000.0 мянга, нийт 95740.0 мянган төгрөгөөр анх баталсан ба 2020.09.24-ны өдрийн 27 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 2000.0 мянган төгрөгөөр нэмж тодотгон татварын орлогыг 92740.0 мянга, хүү торгуулийн орлогыг 5000.0 мянган төгрөгөөр баталжээ.

*Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **1.Татварын орлого** | **92740.0** | **105705.0** | **12965.0** | **114.0** |
| ИОТХ | 6,000.0 | 31,820.1 | 25,820.1 | 530.3 |
| хадгаламжийн хүүгийн орлого | 45,000.0 | 49,069.1 | 4,069.1 | 109.0 |
| ҮХЭХ борлуулсны албан татвар | - | 1,574.0 | 1,574.0 | - |
| Бууны татвар | 1,100.0 | 1,102.0 | 2.0 | 100.2 |
| Улсын тэмдэгт | 1,400.0 | 1,152.6 | (247.4) | 82.3 |
| Газрын төлбөр | 33,240.0 | 13,798.0 | (19,442.0) | 41.5 |
| Хог хаягдлын үйлчилгээний төлбөр | 6,000.0 | 6,230.0 | 230.0 | 103.8 |
| Ус,рашааны нөөц ашигласны төлбөр | | 959.2 | 959.2 | |
| **2.Татварын бус орлого** | **5000.0** | **3297.6** | (1,702.4) | 66.0 |
| 2.1.Хүү торгуулийн орлого | 5,000.0 | 3,297.6 | (1,702.4) | 66.0 |
| **Нийт дүн** | **97740.0** | **109002.6** | **11262.6** | **111.5** |

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 12965.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон хувь хүний орлогын албан татварын орлого, хадгаламжийн хүүгийн орлого, бууны албан татвар, хог хаягдлын үйлчилгээний төлбөрийг тус тус давуулан биелүүлсэн байна.

Иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон хувь хүний орлогын албан татвар 6000.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдаж гүйцэтгэлээр 31820.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Энэ нь 2019 оны ноосны урамшуулал, арьс ширний урамшууллаас суутгасан 10 хувийн татварыг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Харин газрын төлбөрийн орлогыг 41.5 хувь буюу 19442.0 мянга, улсын тэмдэгтийн хураамжийг 82,3 хувь буюу 247.4 мянган төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн ба үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 1574.0 мянга, ус рашаан нөөц ашигласны төлбөр 959.2 мянган төгрөгийн төлөвлөгөөгүй орлого орсон байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 1200.0 мянган төгрөгийн орлогоос 403.2 мянга, соёлын төв 1000.0 мянган төгрөгийн орлогоос 1800.0 мянга, ерөнхий боловсролын сургууль орлого төлөвлөөгүй ба 784.5 мянган төгрөгийн орлогыг тус тус оруулсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 31975.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 28529.0 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2448515.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2010909.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 274285.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд Эрүүл мэндийн төв төсвийн төслийг хүргүүлээгүй байна.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019.12.19-ний өдрийн 15 дугаар тогтоолоор нийт 2508030.0 мянган төгрөгийг баталсан байна.

*Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 65,590.1 | 71,015.2 | 5,425.1 |
| Засаг даргын Тамгын газар | 590,148.2 | 359,431.5 | (230,716.7) |
| Сургууль | 672,659.6 | 796,016.8 | 123,357.2 |
| Цэцэрлэг | 250,752.4 | 276,537.6 | 25,785.2 |
| Эрүүл мэндийн төв | | 391,716.6 | 391,716.6 |
| Соёлын төв | 130,124.9 | 92,457.9 | (37,667.0) |
| Сум хөгжүүлэх сан | | 173,404.8 | 173,404.8 |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 347,449.6 | 347,449.6 |
| **Нийт дүн** | 1,709,275.2 | 2,508,030.0 | 798,754.8 |

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.19-ний өдрийн 15 дугаар тогтоолоор анх баталсан 2603459.9 мянган төгрөгийг 2020.09.24-ний өдрийн 27 дугаар тогтоолоор 95429.9 мянган төгрөгөөр бууруулж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2020.11.27-ний өдрийн А/770 дугаар захирамжаар 7170.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2020.12.30-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 66684.7 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2448515.9 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1240806.7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 347449.6 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 525933.8 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 97740.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 34175.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл

ажиллагааны орлогоос, 24773.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 177637.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 32119.9 мянган төгрөгөөр дутуу, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 59464.6 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн ба улсын төсөвт 50631.3 мянга, орон нутгийн төсөвт 27374.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | Улсын төсөвт төвлөрүүлсэн | ОН төсөвт төвлөрүүлсэн |
|---|---|---|---|---|---|---|
| ИТХ | 71,015.2 | 68,005.7 | 3,009.5 | 95.8 | | 3,009.5 |
| ЗДТГ | 359,431.5 | 347,920.1 | 11,511.4 | 96.8 | | 10,714.7 |
| Сургууль | 770,166.4 | 737,722.3 | 32,444.1 | 95.8 | 29,758.6 | 3,469.9 |
| Цэцэрлэг | 242,873.9 | 224,470.8 | 18,403.1 | 92.4 | 16,766.0 | 1,637.1 |
| Соёлын төв | 92,457.9 | 84,879.3 | 7,578.6 | 91.8 | | 7,578.6 |
| Хүн эмнэлэг | 391,716.6 | 383,655.8 | 8,060.8 | 97.9 | 4,106.7 | 964.9 |
| СХСан | 173,404.8 | 164,255.5 | 9,149.3 | 94.7 | | |
| ОНХСан | 347,449.6 | 274,285.2 | 73,164.4 | 78.9 | | |
| | 2,448,515.9 | 2,285,194.7 | 163,321.2 | 93.3 | **50,631.3** | **27,374.8** |

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2285194.7 мянган төгрөг буюу 93.3 хувьтай байгаа нь Засаг даргын Тамгын газрын зардлыг 11511.4 мянга, ерөнхий боловсролын сургуулиудын урсгал зардлыг 32444.1 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 73164.4 мянга, хүүхдийн цэцэрлэг 18403.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 16. Шинэжинст сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2448515.9** | **2285194.66** | **163321.24** | **93.3** |
| **70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгуул** | **71015.2** | **68005.66** | **3009.54** | **95.8** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 59617.2 | 57198.74 | 2418.46 | 95.9 |
| 80825 Багийн ИНХ-ын дарны урамшуулал | 11398 | 10806.92 | 591.08 | 94.8 |
| **70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын уди** | **359431.5** | **347920.06** | **11511.44** | **96.8** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 280256 | 273224.54 | 7031.46 | 97.5 |
| 80106 Баг, хорооны ҮАЗардал | 52075.5 | 48043.92 | 4031.58 | 92.3 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 900 | 500.00 | 400.00 | 55.6 |
| 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 20200 | 20151.60 | 48.40 | 99.8 |
| 82212 Хур хог хаягдал, орчны бохирдол | 6000 | 6000.00 | 0.00 | 100.0 |
| **70503 Орон нутгийн зорилтот ХОруулал** | **347449.6** | **274285.17** | **73164.43** | **78.9** |
| 80904 Нийгмийн зориулалттай барилга | 347449.6 | 274285.17 | 73164.43 | 78.9 |
| **71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **391716.6** | **383655.81** | **8060.79** | **97.9** |
| 80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 24093.2 | 23128.31 | 964.89 | 96.0 |
| 80302 Нэг иргэнд ногдох нормативаар | 16395.4 | 16358.01 | 37.40 | 99.8 |
| 81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлч | 351228 | 344169.50 | 7058.50 | 98.0 |
| **71702 Соёл урлаг** | **92457.9** | **84879.30** | **7578.60** | **91.8** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 91557.9 | 84879.30 | 6678.60 | 92.7 |
| 80214 Уран бүтээл хийлгэх | 900 | 0.00 | 900.00 | 0.0 |
| **71801 Сургуулийн өмнөх боловсрол** | **242873.9** | **224470.83** | **18403.07** | **92.4** |
| 80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 20207.7 | 18570.64 | 1637.07 | 91.9 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 105.5 | 0.00 | 105.50 | 0.0 |
| 81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 18401.1 | 18400.87 | 0.23 | 100.0 |
| 81834 Боловсролын стандарт, сургалты | 172878.2 | 159991.87 | 12886.33 | 92.5 |
| 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 31281.4 | 27507.45 | 3773.95 | 87.9 |
| **71802 Ерөнхий боловсрол** | **762103.4** | **729735.29** | **32368.11** | **95.8** |
| 80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 94875.5 | 91405.53 | 3469.97 | 96.3 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 1599.6 | 1598.62 | 0.98 | 99.9 |
| 81801 үдийн цай хөтөлбөр | 16691.1 | 12007.20 | 4683.90 | 71.9 |
| 81806 Дотуур байрны үйлчилгээ | 103203.4 | 82162.20 | 21041.20 | 79.6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 81834 Боловсролын стандарт, сургалты | 400126.4 | 397106.41 | 3019.99 | 99.2 |
| 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 145607.4 | 145455.33 | 152.07 | 99.9 |
| **71806 Насан туршын болон албан бус б** | **8063** | **7987.05** | **75.95** | **99.1** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 8063 | 7987.05 | 75.95 | 99.1 |
| **72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжи** | **173404.8** | **164255.50** | **9149.30** | **94.7** |
| 82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих | 173404.8 | 164255.50 | 9149.30 | 94.7 |

*Эх сурвалж: :Шинэжинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 2 байгууллага 62885.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 3 байгууллага 79361.1 мянга, нийт 142247.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 25220.9 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 29495.3 мянга, хашаа байшин, орон сууцны хөнгөлөлтөд 10000.0 мянга, түрээсийн сурах бичгийн үнэ 630.4 мянга, сорьц тээвэрлэсний тээврийн зардал 39.7 мянга, Эрүүл мэндийн газраас эмийн санхүүжилт 8130.0 мянга, хамтарсан багийн зардал 1500,0, хүн ам, орон сууцны тооллогын зардал, мал тооллогын зардал 846,2, “Хүчирхийлэлгүй сум” төслийн санхүүжилт 6300.00 тендерийн баримт бичгийн үнэ 140,0 мянга, өмнөх оны нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 1815,5 өвс тэжээлийн үнэ 58129,0 мянган төгрөг нийт 135947.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 6300.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

| Үзүүлэлт | ЗДТГ | ИТХ | ЕБС | Цэцэрлэг | ЭМТ | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | **78730.7** | | **47341.8** | | **16174.5** | **142247.0** |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | | | | | |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | | 46711.4 | | 16174.5 | 62885.9 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 78730.7 | | 47341.8 | | 16174.5 | 79361.1 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | **72430.7** | | **47341.8** | | **16174.5** | **135947.0** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 72430.7 | | | | 8169.7 | 80600.4 |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | | | 630.4 | | | 630.4 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | | 25220.9 | | | 25220.9 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | | 21490.5 | | 8004.8 | 29495.3 |
| **Төсөвт төвлөрүүлсэн** | **6300.0** | | | | | **6300.0** |

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 126 мэдээллийг хугацаанд нь, 29 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

*Хүснэгт 17. Шилэн дансны мэдээлэл*

| д/д | хугацаа | төрөл | удаа | хугацаанд нь мэдээлсэн | хугацаа хоцроосон | хоцроосон мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 12 | 12 | 9 | 3 | Дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгийн оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессийн күйлийн жагсаалт, гүйцэтгэл, |
| 2 | Хагас жил | 3 | 3 | 3 | - | |
| 3 | Улирал бүр | 2 | 8 | 6 | 2 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл |
| 4 | Сар бүр | 5 | 60 | 49 | 11 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 2 сар, 5 сар, 8 сар, 9 сар, 10 сар, Улсын төсвийн болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл 5 сар, 9 сар, 10 сар, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл 9 сар, 10 сар, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессийн зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 9 сар, |
| 5 | Тухай бүр | 6 | 72 | 59 | 13 | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 5 сар, 8 сар, 9 сар, 10 сар, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 9 сар, 10 сар, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтын хэмжээ 9 сар, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага, үүсгэсэн аливаа шийдвэр 5 сар, 8 сар, 9 сар, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр хураамж , зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 9 сар, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн 9 сар 10 сарууддад тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. |
| НИЙТ | | 30 | 155 | 126 | 29 | |

*Эх сурвалж.Шинэжинст сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас*

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байр 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна. Зөвлөмжийн биелэлтийг сумын засаг даргын 2020.05.29-ний өдрийн 137 тоот албан бичгээр ирүүлж биелэлтийг тооцсон байна.

*Хүснэгт 18* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | - | 1 | - | | | 100.0 |
| Нийт | 1 | - | 1 | - | | | 100.0 |

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан ба 4 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 3 байгууллагын санхүүгийн тайланд түүвэрт хамруулж 1 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан 4 байгууллагад "Зөрчилгүй" санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 392266.8 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс 298.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 77712.9 мянган төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 заалт бүхий зөвлөмж өгч, 314225.6 мянган төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулжээ. /Хавсралт 2./

Шинэжинст сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 9181.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залруулж, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах 9293.8 мянган төгрөгийн 4 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

*Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга*

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Бараа материалын тодруулга тайланд Соёлын төвийн бичгийн хэргийн материал, аж ахуйн материал түлш шатах тослох материалын орлого зарлага нийт 2288.6 мянган төгрөгөөр дутуу. ЗДТГ-ын эм боох материал болон аж ахуйн материал 4025.0 мянган төгрөгөөр дутуу, Эрүүл мэндийн төвийн түлш шатах тослох материалын орлого зарлага 2405.0 мянган төгрөгөөр дутуу, хүүхдийн цэцэрлэг бусад хангамжийн материал 462.7 мянган төгрөг нийт 9181.3 мянган төгрөгийн орлого зарлагыг тус тус дутуу нэгтгэсэн.
- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгийн оны эхний хуримтлагдсан элэгдэл 1555723.7 мянга, оны эцсийн хуримтлагдсан элэгдэл 1955565.1 мянган төгрөгийг нэмэх дүнтэй илэрхийлсэн байна.

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар аудитлагдсан тайлангийн 2020 оны эцсийн үлдэгдлийг Э-тайлангийн 2021 оны эхний үлдэгдлээр зөв оруулсан эсэхийг нягталж тодруулах шаардлагатай мөн нягтлан бодогч нарын хариуцлагыг дээшлүүлэн санхүүгийн программын эцсийн үлдэгдлийг э-тайлангийн үлдэгдлээр зөв хаалт хийсэн эсэх дээр сумын Санхүүгийн албаны дарга хянаж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 4.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

4.1.1. **Илрүүлэлт:** Төсөвт байгууллагын болон сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

4.1.2. **Эрсдэл:** Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

4.1.3 **Өгсөн зөвлөмж:** Сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэлд сумын Төрийн сангийн мэргэжилтэн, санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад санхүүгийн албаны дарга тавьж байгаа дотоод хяналтаа сайжруулах.

4.1.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

4.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

4.2.2 **Илрүүлэлт:**

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 126 мэдээллийг хугацаанд нь, 29 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна..

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

4.2.2 **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

4.2.3 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

4.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

4.3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

4.3.1. Илрүүлэлт:

4.3.1. Богино хугацаат өр төлбөр нь 14427.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд эрүүл мэндийн төвийн өглөг 12758.3 мянган төгрөг буюу 88.4 хувийг эзэлж байгаа нь голлох нөлөө үзүүлж байна.Үүнд 5325.1 мянган төгрөгийн эмийн өглөг, 6543 .8 мянган төгрөгийн ХАОАТ-ын өглөг, 889.5 мянган төгрөгийн үйлдвэрчний эвлэлийн өглөг шинээр үүссэн байна. Сумын Төрийн сан нь ЭМТ-ийн цалингаас суутгасан суутгалуудыг ОНО-д төвлөрүүлээгүй байхад тавих хяналт хангалгүй байгаагаас ХХОАТ-ын 6543.8 мянган төгрөгийн өглөгтэй гарч тайлант онд төсвийг хэтрүүлэн зарцуулж өр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.”Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**4.3.2 Эрсдэл**: Нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналт суларснаас төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, санхүүгийн үүрэг хариуцлага хүлээх.

4.3.3 **Өгсөн зөвлөмж:** Сумын Төрийн сан нь төрийн сангийн төлбөр тооцоог гүйцэтгэхдээ анхан шатны баримтад үндэслэн гүйлгээг хийх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж өглөг, авлага үүсгэхгүй ажиллахад анхаарч ажиллах.

4.4.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

4.4. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.4.1. Илрүүлэлт:

Хүүхдийн цэцэрлэг нь оны эхэнд 2783.5 мянган төгрөгийн авлагатай бөгөөд үүний 2350.0 мянган төгрөг 2012 онд үүссэн "Ган мөнхжин" ХХК-аас авах зураг төсвийн авлага байна. Үүний хариуцагч нь нас барсан тул эзэн холбогдогчгүй авлага байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "Үнэн зөв байх", Эрх ба үүрэг , Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байх.

**4.4.3 Эрсдэл:** Авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй, зөрүүтэй баталгаажуулсан байх.

**4.4.4 Өгсөн зөвлөмж:** Авлагыг барагдуулах арга хэмжээг авч цаашид өглөг, авлага үүсгэхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР Н.БҮНЧИНСҮРЭН 2021.03.25

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ 2021.03.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ 2021.03.25

## 5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Шинэжинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/16/СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Шинэжинст сумын Засаг дарга | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Бараа материалын тодруулга тайланд Соёлын төвийн бичгийн хэргийн материал, аж ахуйн материал түлш шатах тослох материалын орлого зарлага нийт 2288.6 мянган төгрөгөөр дутуу. ЗДТГ-ын эм боох материал болон аж ахуйн материал 4025.0 мянган төгрөгөөр дутуу, Эрүүл мэндийн төвийн түлш шатах тослох материалын орлого зарлага 2405.0 мянган төгрөгөөр дутуу, хүүхдийн цэцэрлэг бусад хангамжийн материал 462.7 мянган төгрөг нийт 9181.3 мянган төгрөгийн орлого зарлагыг тус тус дутуу нэгтгэсэн. | 9181.3 | Санхүүгийн тайланд залруулсан. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Сайханбаяр Х.Дагважав |
| 2 | Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгийн оны эхний хуримтлагдсан элэгдэл 1555723.7 мянга, оны эцсийн хуримтлагдсан элэгдэл 1955565.1 мянган төгрөгийг нэмэх дүнтэй илэрхийлсэн байна. | | Санхүүгийн тайланд залруулсан. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Сайханбаяр Х.Дагважав |
| 3 | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. | - | Зөвлөмж өгсөн. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Сайханбаяр Х.Дагважав |
| 4 | Төсөвт байгууллагын болон сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна. | - | Зөвлөмж өгсөн. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Сайханбаяр Х.Дагважав |
| 5 | Сумын Төрийн сан нь ЭМТ-ийн цалингаас суутгасан суутгалуудыг ОНО-д төвлөрүүлээгүй байхад тавих хяналт хангалгүй байгаагаас ХХОАТ-ын 6543.8 мянган төгрөгийн өглөгтэй гарч тайлант онд төсвийг хэтрүүлэн зарцуулж өр үүсгэсэн байна. | 6543.8 | Зөвлөмж өгсөн | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Сайханбаяр Х.Дагважав |
| 6 | Хүүхдийн цэцэрлэг нь оны эхэнд 2783.5 мянган төгрөгийн авлагатай бөгөөд үүний 2750.0 мянган төгрөг 2012 онд үүссэн "Ган мөнхжин" ХХК-аас авах зураг төсвийн авлага байна. Үүний хариуцагч нь нас барсан тул эзэн холбогдогчгүй авлага байна | 2750.0 | Зөвлөмж= өгсөн | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Сайханбаяр Х.Дагважав |
| **ДҮН** | | **18475.1** | | | |

__________oOo________

**6. Хавсралт 2.: Харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт** /мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянган төгрөг/ | Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт. | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Ерөнхий боловсролынсургууль | | 9,950.0 | | | |
| 1 | “Санко Маркетинг Монголиа” ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950.0 мянган төгрөгийг шилжүүлсэн ч тухайн хөрөнгийг хүлээж аваагүй бөгөөд уг хөрөнгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. | 9,950.0 | санхүүгийн тайланд залруулсан | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ш.Даваацэцэн, Х.Гантулга |
| 2 | Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 80 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс пээш үнийн дүн бүхий орлогын 29978.4 мянга, зарлагын 42992.9 мянга нийт 72971.3 мянган төгрөгийн 69 мэдээллийг хоцроож байршуулсан байна. Тушаал шийдвэртэй холбоотой 7 мэдээлэл хоцроосон нь байгууллагын даргын 24 тушаал хугацаа хоцроож мэдээлсэн байна. | | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ш.Даваацэцэн, Х.Гантулга |
| | Засаг даргын Тамгын газар | 363,485.5 | | | |
| 1 | 2019 онд актлагдсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг дахин үнэлгээний нөөц дансыг 298800,6 мянган төгрөгөөр хасагдуулаагүй. | 298,800.6 | Санхүүгийн тайланд залруулсан | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Л.Батхуяг, Х.Доржсамбуу |
| 2 | Цагийн байдал хүндэрсэнтэй холбоотойгоор отрын малчныг эргэх, төрийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор шатахууны бэлтгэн нийлүүлэгчид 3100,0 мянган төгрөгийн шатахуун шилжүүлж, шатахуун хүлээн аваагүй байхад бараа материалын орлогоор бүртгэсэн. | 3,100.0 | Санхүүгийн тайланд залруулсан | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Л.Батхуяг, Х.Доржсамбуу |
| 3 | Шилэн дансны сайтад 151 мэдээ мэдээлэхээс мэдээллийг бүрэн байршуулсан бөгөөд үүнээс 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | - | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Л.Батхуяг, Х.Доржсамбуу |
| 4 | Ойн ангиас хуваарилсан өвсний тооцоог санхүүгийн тайланд тусгаагүй 61584,9 төгрөгийн өвсний авлагатай байхад тайланд тусгаагүй байна. | 61,584.9 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Л.Батхуяг, Х.Доржсамбуу |
| | Хүүхдийн цэцэрлэг | 298.3 | | | |
| 1 | НДШ-д 298,3 мянган төгрөгийг илүү төлж авлага үүсгэсэн | 298.3 | Төлбөрийн акт тогтоосон | Дарга, нятлтан бодогч | Б.Оюунчимэг, Х.Гантулга |
| | Эрүүл мэндийн төв | 18,533.0 | | | |
| 1 | Тухайн байгууллага нь цалин НДШ-ийн зардлыг 4043,1 мянган төгрөгөөр хэмнэж төвлөрүүлсэн ба тайланд онд өглөг 7325,7 мянган төгрөг ХХОАТ,ҮЭ-ийн өглөгтэй гарч төсвийг 3282,6 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна | 3,282.6 | Зөвлөмж өгсөн | Эрхлэгч, Нягтлан бодогч | З.Энхбаяр Н.Нямдорж |
| 2 | ЭМГ-аас 16308,3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй эм олгосон ба сумын ЭЭС нь ЭМТ-д захиалгын дагуу өгч, оны эцэст сумын ЭЭС-д 8004,2 мянган төгрөгийн эм байгааг ЭМТ орлого аваагүй байна. | 12,047.3 | Зөвлөмж өгсөн | Эрхлэгч, Нягтлан бодогч | З.Энхбаяр Н.Нямдорж |
| 3 | Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 85 мэдээллээс бүтэн жилээр байршуулах 11 төрлийн 1 мэдээлэл, хагас жилээр байршуулах 4 төрлийн 4 мэдээлэл, сараар байршуулах 36 төрлийн 16 мэдээлэл, тухай бүр байршуулах 96 төрлийн 44 мэдээлэл, нийт 65 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. | - | Зөвлөмж өгсөн | Эрхлэгч, Нягтлан бодогч | З.Энхбаяр Н.Нямдорж |
| 4 | : Тайлант онд НДШ-ээс 328,7 мянга, урьд оны эмийн авлагын үлдэгдлээс 469,4 мянган төгрөгийн авлагатай гарч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй. | 798.1 | Зөвлөмж өгсөн | Эрхлэгч, Нягтлан бодогч | З.Энхбаяр Н.Нямдорж |
| 5 | Тайлант онд нягтлан бодогч 1-р сарын шатахууны 2405,0 мянган төгрөгийн орлогыг шууд зардлаар бүртгэж бичилт хийснээс нярвын тайлангаас зөрүүтэй байсныг залруулж бүртгэв. | 2,405.0 | Санхүүгийн тайланд залруулсан | Эрхлэгч, Нягтлан бодогч | З.Энхбаяр Н.Нямдорж |
| | Нийт дүн | 392,266.80 | | | |

oOo